

## 114 ДАЙСАН

1. Та дайсныхаа арга залиг мэддэг үү?
2. Та дайсныхаа хамсаатанг мэддэг үү?
3. Та дайснаа хэрхэн ялахаа мэддэг үү?

**114.1 ТА ДАЙСНЫХАА ЗАЛЬ МЭХИЙГ МЭДЭХ ҮҮ?**

4.  Сатан яагаад таныг ганцаараа ажиллахыг хүсдэгийг та мэдэх үү?
5.  Сатан бол таны амьдралд нөлөөлж сүйтгэж, ахиц дэвшилд тань саад болохыг оролддог бодит сүнслэг оршнол гэдгийг та мэдэх үү?
6.  Сатан дайрахаа зогсоохгүй гэдгийг та мэдэх үү?
7.  Таны ололт амжилтыг Сатан таны эсрэг хэрхэн ашигладагийг та мэдэх үү?
8.  Сатан болон түүний муу ёрын сүнснүүдийг ялах ёстойгоо та мэдэх үү?
9.  Таны зүрх сэтгэлд амар амгалан байх нь ялалтын шинж тэмдэг гэдгийг та мэдэх үү?
10.  Сатан өөрийн мөн чанараа нуудаг гэдгийг та мэдэх үү?
11.  Эргэн тойрныхоо хүмүүсийн амьдралд Сатаны үйл ажиллагаа байгаагийн шинж тэмдгийг та мэдэх үү?
12.  Таны амьдралд Сатан хэрхэн нөлөөлж байдгийг та мэдэх үү?
13.  Бурханы үзэн яддаг зүйлийг Сатан өөрөөр тань хийлгэхэд хүргэдэг гэдгийг та мэдэх үү?
14.  Сатан болон хуурамч бурхдын дагалдагчдын эцсийн хувь заяаг та мэдэх үү?
15.  Яагаад Бурханы үгнээс гадуурх аливаа зүйл нь нүгэл болдгийг та мэдэх үү?
16.  Бурханаас таныг нүгэл салгадгийг та мэдэх үү?
17.  Дараахь зүйл танд хамааралтай эсэхийг шалгах, тэдний довтолгоог ялах

**114.2 Сатан ба түүний муу ёрын сүнснүүдийн заль мэх**

1. [ ] Ева, Адам хоёрт үйлдсэн шигээ уруу таталтын сүнс илгээдэг.
2. [ ] Таны амьдралын нэн тэргүүний зүйлийг бүдгэрүүлж, шүтээн шүтэхэд хүргэдэг. Шунал бол шүтээн шүтэх явдал юм.
3. [ ] Зовлонгийн сүнсийг илгээх ( ЭЗЭНий Сүнс Саулаас салсан бөгөөд ЭЗЭНээс ирсэн муу сүнс түүнийг айлган сүрдүүлэв. (1Самуел 16:14)
4. [ ] Оюун санааг өдөөн хатгаж, хэрэггүй зүйлд турхирна. (Давид ард түмнээ тоолсныхоо дараа сэтгэл нь шаналж ЭЗЭНд хандан "Би хийсэн зүйлээрээ их нүгэл үйлдэв. Харин одоо ЭЗЭН минь Өөрийн зарцынхаа нүглийг өршөөн хэлтрүүлээч. Би үнэхээр мунхаг хэрэг үйлдэв гэж залбирав." (2 Самуел 24:10)
5. [ ] Иовт хийсэн шиг сорилт, шалгалтыг үүсгэдэг.
6. [ ] Бурханы үйлчлэгчид болон Түүний ард түмний эсрэг босдог. Бурханаас таны амьдралд ирэх ерөөлийг хаадаг.
7. [ ] Бурханы үгийг хүмүүсийн зүрх сэтгэлээс салгадаг. (Зарим хүмүүс зам дагуух тарьсан үр мэт. Үгийг сонсмогц Сатан ирж, тэдний дотор тарьсан үгийг булааж авдаг. (Марк 4:15)
8. [ ] Хүмүүст гамшиг, өвчин тусгадаг.
9. [ ] Агаар дахь муу ёрын сүнснүүдийн хүчээр ертөнцийг удирдах. (Та нар өөрсдийн нүгэл, хилэнц дотор үхсэн байв. Та нар урьд нь нүгэл, хилэнц дотор энэ ертөнцийн заншлын дагуу агаарын хүчний ноёрхогч буюу эдүгээ дуулгаваргүй хөвгүүд дотор ажиллаж буй сүнсийг дагаж явсан. Тэдний дунд бид ч бас бүгдээрээ урьд нь махан бие болон санаа бодлын хүслүүдээ өөгшүүлэн махан биеийнхээ хүсэл тачаалуудаар амьдарч байв. Мөн бусдын адил төрөлхөөс уур хилэн хүртэх хүүхдүүд байсан. (Ефес 2:1-3)
10. [ ] Хүмүүсийг тайвшруулж, залхуу байдалд оруулах. Цагийг дэмий үрэх нь амраах эсвэл сэргээх явдал биш. Залхуурал хүмүүсийг буруу зам руу хөтөлдөг. Тэд буулт хийж итгэл, үнэнийг орхидог. Ингэхдээ тэд Бурхан ба хүний хоорондын харилцааг тасалдуулдаг. (Ингэсэн нь биднийг Сатан мэхэлж далимдуулах вий гэсэндээ юм. Учир нь түүний хөнөөх санааг бид ямар мэдэхгүй биш. (2 Коринт 2:11)
11. [ ] Бурханы хүүхдүүдийг улаан буудай шиг шигшихийг шаарддаг. "Симон оо, Симон оо, чамайг улаан буудай мэт шигшихийн тулд Сатан зөвшөөрөл гуйсан. (Лук 22:31)
12. [ ] Сайн мэдээг түгээхэд саад болох, зогсоох, таслах бүх төрлийн аргыг ашигладаг.

**Сэрэмжлүүлэг:****114.3 ТА ДАЙСНЫХАА АРГА ЗАЛИЙГ МЭДЭХ ҮҮ?****Сатаныг өөгшүүлэх**

- а)  Багийг бутаргахад оролцох
- б)  Үзэн ядалтад хөтлөгдсөн
- в)  Бусдад бүдүүлэг, ёс зүйгүй хандах
- г)  Ихэмсэг, бардам сүнс
- д)  Оюун санааны хүсэл болон Сүнсний эсрэг махан биеийн шунал тачаалын хойноос хөөцөлдөх
- е)  Хувиа хичээх, зөвхөн өөрийн ажлыг бодох
- ё)  Сайн дүр эсгэх ба хоёр нүүр гаргах
- ж)  Сайн мэдээг хүлээн авсан боловч тав тухаа бодох, үгэнд эргэлзэж, сайн мэдээ түгээхээс ичих
- з)  Сайн мэдээг өөрийн амьдралд эцэслээд хойч үедээ дамжуулдаггүй
- к)  Бурханы ажлыг зогсоодог

**Бурханд таалагдах**

- а)  Багийг нэгтгэхэд оролцох
- б)  Хайранд хөтлөгдсөн
- в)  Бусдад хүндэтгэлтэй, анхааралтай хандах
- г)  Даруу, гэмшсэн сүнс
- д)  Сүнслэг үнэт зүйлсийг мэдэж үнэнчээр сахиж, дагаж мөрдөх
- е)  Зориулах, тэсвэрлэх оюун ухаан
- ё)  Улирал үл хамааран сайн тариалах
- ж)  Сүнслэг бэлгүүдээр сүмд үйлчлэх
- з)  Сайн мэдээний өвийг хойч үеийнхэнд үлдээх
- к)  Бузар мууг зогсоож, наманчилж, зөвийг хийхэд суралцах

**14.4 БУРУУ СУРГААЛЫГ шалгах жагсаалт****Анхаарна уу**

1.  Сургаал нь судрыг нэмэх, мушгин гуйвуулах эсвэл үгүйсгэн төлөөлөгч буюу эш үзүүллэгийн эрх мэдлийг тунхагладаг уу?
2.  Сургаал нь хуурамч бурхдыг, тэр дундаа шунахай зан, Бурханы үнэн мөн чанарыг мушгин гуйвуулахыг өөгшүүлдэг үү?
3.  Сургаал нь Есүстэй эн тэнцүү эсвэл илүү эрх мэдэлтэй гэж заадаг уу?
4.  Үйлдлүүд нь Христийг Эзэн болохыг, Түүнийг махан биеэр төрснийг, Түүний мөнхийн мөн чанар буюу Бурханаас ирсэнийг, цовдлогдон нас барсныг болон дахин амилалт зэргийг үгүйсгэж байна уу?
5.  Бидний авралын төлөө загалмай дээрх Христийн үхлээр бий болсон гэм нүглийн цагаатгалыг сургаал заагчид нь няцаах эсвэл гуйвуулж байна уу?
6.  Багш нар нь хууль зүйн талаар зааж, Хуучин Гэрээний хуулиудыг нэмж эсвэл хүний санаачилсан зан үйлийг заавал дагахыг шаарддаг уу?
7.  Танай багш нар эш үзүүлэгчид болон элч нарын судрын дагуу сургаалийг үгүйсгэж эсвэл өөрчилдөг үү?
8.  Танай багш нар элч төлөөлөгчдийн үгүйсгэж итгэлийг эсэргүүцэж байна уу?
9.  Танай багш нар судрын жинхэнэ утгыг гуйвуулж, өөрсдийн онол сургаалыг батлахын тулд судрыг ашигладаг уу?
10.  Танай багш нар хувь хүнийхээ илчлэлтийг судрын эрх мэдлээс дээгүүрт өргөдөг үү?
11.  Танай багш нар чөтгөрийн зорилгод нийцсэн (хувийн эсвэл байгууллагын ашиг) амлалт өгч байна уу? **ТА ДАЙСНЫХАА ЗАЛЬ МЭХИЙГ МЭДЭХ ҮҮ?**
12.  Танай багш нар дэлхий дээр өөрсдийнхөө нэр алдар, эд баялагийг эрэлхийлж эсвэл сурталчилж байна уу?

### 114.5 Христийн дахин ирэлтийг шалгах хуудас

1.  Гурав дугаар сүм баригдаж, тахил өргөх ёслол эхэлсэн
2.  Антихрист гарч ирэх
3.  Ариун Сүнснийг үгүйсгэх
4.  Хуурамч эш үзүүлэгчид гарч ирэх
5.  Эцсийн өдрийг тунхагла, Есүс Христийн эргэн ирэх өдрийг эш үзүүл
6.  Сударт бичигдсэнчлэн үлэмж их зовлон эхлэх
7.  Ертөнц нь Ноагийн үетэй адил, үгийг үл ойшоож, амийн үгийг хэрэгсэхгүй байх
8.  Бэлэн бай. Ариун Сүнсний ажлыг тусгах гэрлээ өөрөөрөө дамжуулан гэрэлтүүл. Эзэнд хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд үйлчилж, мөргөж, залбирч, нөхөрлөөрэй.

### 114.6 Зөвшөөрөгдөхүйц зориулалтын хяналтын шалгуур

1.  Бүх зүрх сэтгэл, оюун ухаанаараа хийж, авьяас, цаг хугацаа, бие махбодь, эзэмшил, зүрх сэтгэл бүхнээ нэг цул болгон зориулах (Ром 12:1-2; Шастирын дэд 16:9)
2.  Бурхан нүглийг шүүж, Өөрийг нь эрэлхийлдэг хүмүүсийн хүчийг шагнадаг.
3.  Шалтаг тоочихгүйгээр хийх, илүү гарснаа эсвэл төстэй санаагаар өргөхгүй байх.

### 114.7 ТА ДАЙСНЫХАА ХАМСААТНЫГ МЭДЭХ ҮҮ?

Муу ёрын сүнснүүд хөөгдсөний дараа хаашаа явсан бэ? Тэд алга болсон уу? Үгүй. Тэд дэлхий дээр үлдэж шүүлтийн өдөр хүртэл эрх мэдлээ хэрэгжүүлдэг. Тэнгэр, газрыг бүтээгээгүй дэлхийн бүх бурхад нь Есүс Христийг үгүйсгэгчдийн хамт галт нуурт хаягдахад зориулагджээ. Эдгээр сүнснүүд амрах газар хайж, Бурханы үг байхгүй хүмүүсийг хайдаг. Муухай хэл яриа, үгс нь эдгээр бузар муу сүнснүүдийг

урьдаг. Эдгэрээд дараа нь дахин өвддөг өвчтөн шиг өвчний эх үүсвэрийг бүрэн арилгахгүй л бол бүрэн гүйцэд эдгэрэл болохгүй.

Үүний нэгэн адил муу ёрын сүнснүүдээс ангид байхын тулд Их Эзэний Сүнсээр бүрэн дүүрэн сэлбэгдэж, Хурганы цусаар дахин төрж, Ариун Сүнсээр дүүрч, Бурханы үгээр өдөр бүр угаагдаж дахин сэргэх хэрэгтэй.

Эдгээр энгийн үйл ажиллагаа нь Бурханы хүүхдүүдэд заавал байх ёстой.

Энэ нь: " Бузар сүнс хүнээс гарахдаа, усгүй ангамал газраар хэрэн хэсэж амралтыг хайвч түүнийгээ олддоггүй. Тэгээд тэр "Би хаанаас гарлаа, тэр гэртээ эргэж очъё" гэж хэлдэг. Буцаж ирэхэд нь, түүнийг хэн ч эзлээгүй бөгөөд шүүрдсэн, цэгцтэй болсон байхыг тэр хардаг. Тэгээд тэр явж, өөрөөсөө дор өөр долоон сүнсний хамт тийшээ орж, тэндээ амьдардаг аж. Өнөөх хүний хувьд сүүлчийнх нь байдал анхныхаасаа бүр дорддог. Энэ муу үеийнхэн ч мөн тийм байх болно гэж айлдав." гэж бичигдсэн.

Тэгээд үхэл ба Үхэгсдийн орон галт нуур руу хаягдлаа. Энэ бол хоёр дахь үхэл буюу галт нуур болой. Хэрэв хэн нэгний нэр амийн номд бичигдсэн нь олдохгүй бол галт нуурт хаягдсан байна. (Илчлэлт 20:14-15 )

Чи тэдэнд "Тэнгэрүүд ба газрыг бүтээгээгүй бурхад газар дэлхийгээс болон тэнгэрүүдийн доороос устах болно " гэж хэл (Иеремиа 10:11)

### **Өөрийн бодол санааг анхаарч үзээрэй**

“Гуйгаагүй хүмүүст Би Өөрийгөө илчилж, Намайг эрээгүй хүмүүст Би олдов. Миний нэрийг дуудаагүй үндэстэнд «Би энд байна, Би энд байна» гэж Би айлдав. 2 Өөрийн бодлыг дагаж, буруу замаар явагч, бослого гаргагч ард түмэн уруу Би бүхэл өдрийн турш мутраа сунгасан. 3 Энэ ард түмэн бол Миний нүүрэн дээр Намайг байнга доромжлон, цэцэрлэгт тахил өргөн, тоосгон дээр үнэртнийг шатааж, 4 булшнуудын дунд сууж, нууц газруудад шөнийг өнгөрөөн, гахайн мах идэн, савандаа бузар махны шөлийг хийдэг бөгөөд, 5 «Зогс. Над уруу бүү ойртогтун. Учир нь би чамаас илүү ариун» гэж хэлдэг. Тэд бол Миний хамарт үнэртэх утаа, бүх л өдөржин шатдаг гал юм. (Исаиа 65:1-5)

Та нар өөрсдийн нүгэл, хилэнц дотор үхсэн байв. Та нар урьд нь нүгэл, хилэнц дотор энэ ертөнцийн заншлын дагуу агаарын хүчний ноёрхогч буюу эдүгээ дуулгаваргүй хөвгүүд дотор ажиллаж буй сүнсийг дагаж явсан. Тэдний дунд бид ч бас бүгдээрээ урьд нь махан бие болон санаа бодлын хүслүүдээ өөгшүүлэн махан биеийнхээ хүсэл тачаалуудаар амьдарч байв. Мөн бусдын адил төрөлхөөс уур хилэн хүртэх хүүхдүүд байсан. (Ефес 2:1-3)

16. □ Таны бодол санаа Бурханы хүслийн эсрэг биш эсэхийг шалгадаг уу?

17. □ Дайсан үргэлж том, алдартай зүйлийг эрэлхийлдэг харин Бурхан нарийн ширийн зүйлд анхаардаг гэдгийг та мэдэх үү?

#### 114.8 ТА ДАЙСНАА ХЭРХЭН ЯЛАХЫГ МЭДЭХ ҮҮ?

##### А, Ариун Сүнсний хүчээр

Харин хэрэв би Бурханы Сүнсээр чөтгөрүүдийг зайлуулдаг бол Бурханы хаанчлал та нар дээр ирчихээд байна. (Матай 12:28)

Миний дотор та нарыг амар амгалан байг гэж Би та нарт эдгээр зүйлийг хэллээ. Ертөнцөд та нар зовлонтой байна. Гэвч зоригтой байгун. Би ертөнцийг ялсан гэж айлдлаа. (Иохан 16:33)

Өшөө авах нь минийх. Тэдний хөл алдах тэр цагт Би хариугаа авах болно.Тэдний гамшгийн өдөр ойртож байна. Тэдэнд нүүрлэн тулгарах зүйлс нь тэдэн уруу яарч байна. (Дэд хууль 32:35 )

Хайртууд минь, хэзээ ч өшөө хонзонг бүү ав. Учир нь өшөө авалт нь Минийх,Би буцааж төлнө" гэж бичигджээ. (Ром 12:19 )

Өшөө авалтын Бурхан болох ЭЗЭН, Өшөө авалтын Бурхан , гэрэлтээч. (Дуулал 94:1)

ЭЗЭН та нарын төлөө байдана. Та нар чимээгүй бай. (Египетээс гарсан нь 14:14)

##### Б, Бүх нэрсээс дээгүүрх Есүс Христийн нэрээр

Есүс- Хэрэв та нар Миний нэрээр юуг ч Надаас гуйвал, Би түүнийг чинь хийнэ. (Иохан 14:14) Есүс - "Хэрэв хэн нэгэн Намайг хайрлавал, тэр хүн Миний үгийг сахина. Миний Эцэг түүнийг хайрлана. Бид түүн уруу очиж түүнтэй хамт өөрсдийн байраа байгуулна." (Иохан 14:23)

Тэнгэр газар үгүй боловч, Миний үгс огтхон ч үгүй болохгүй. (Матай 24:35)  
Иймээс явж, бүх үндэстнийг дагалдагч болгогтун. Эцэг, Хүү, Ариун  
Сүнсний нэрээр тэдэнд баптисм хүртээж, Миний чамд тушаасан бүгдийг  
сахин биелүүлэхийг тэдэнд заа. Харагтун, үеийн төгсгөл хүртэл би та  
нартай үргэлж хамт байх болно гэж айлдав. (Матай 28:19-20)

## **В, Бэлтгэгдсэн байх**

" Нааш ир. Хамт хэлэлцье" гэж ЭЗЭН айлдаж байна. "Та нарын нүглүүд  
час улаан мэт боловч цас шиг цагаан болно. Тэдгээр нь хүрэн улаан боловч  
ноос шиг болох болно. Хэрэв та нар зөвшөөрч, дуулгавартай дагавал, энэ  
газрын хамгийн сайныг иднэ. Харин та нар эсэргүүцэж босвол, илдээр  
цавчигдана" гэж ЭЗЭНий ам айлдаж байна. (Исаиа 1:18-20)

Харин хэрвээ Би Бурханы Сүнсээр чөтгөрүүдийг зайлуулдаг бол Бурханы  
хаанчлал та нарт ирчихээд байна. Тиймээс Бурханд захирагдагтун.  
Диаволыг эсэргүүц. Тэгвэл тэр та нараас зайлна.  
(Матай 12:28; Иаков 4:7)

" Би алс холын Бурхан биш, харин ойрхон байх Бурхан уу?" гэж ЭЗЭН  
тунхаглаж байна. 24 "Би түүнийг харахгүйгээр хүн өөрийгөө хоргодох  
газар нууж чадах уу?" гэж ЭЗЭН тунхаглаж байна. "Би тэнгэрүүд болон  
газрыг дүүргэдэггүй гэж үү?" гэж ЭЗЭН тунхаглаж байна.  
(Иеремиа 23:23-24)

## **Г, Түүнд итгэ**

Бид Түүний хүслийн дагуу юуг ч гуйсан, Тэр биднийг сонсдог гэдэг нь  
Түүний өмнө бидэнд байгаа итгэл зориг юм. 15 Бид юуг ч гуйсан, Тэр  
биднийг сонсоно гэдгийг бид мэдвэл, бид Түүнээс гуйснаа авсан болохыг  
мэднэ. 16 Хэрэв хэн нэг нь үхэлд хүргэхгүй нүгэл үйлдэж байгаа ах дүүгээ  
харвал, залбиран гуй. Тэгвэл үхэлд хүргэхгүй нүгэл үйлдэгсдэд амийг Тэр



өгнө. Үхэлд хүргэх нүгэл гэж бий. Үүний төлөө залбир гэж би хэлэхгүй. 17 Зөвт бус байдал нь бүгдээрээ нүгэл мөн. Үхэлд хүргэхгүй нүгэл гэж бий. (1 Иохан 5:14-17)

### Г, Үнэнийг мэдэх - Худлыг үгүйсгэх

Бурханаар төрсөн хэн боловч нүгэл үйлддэггүйг бид мэднэ. Харин Бурханаар төрсөн Тэрээр түүнийг хамгаалдаг бөгөөд муу нэгэн түүнд хүрэхгүй. 19 Бид Бурханых, харин бүх ертөнц нь муу нэгний дотор байдгийг мэднэ. 20 Бурханы Хүү ирээд, бидэнд үнэн Нэгэнийг мэдүүлэхийн тулд ухааныг өгснийг бид мэднэ. Бид тэрхүү үнэн Нэгэн болох Түүний Хүү Есүс Христийн дотор байна. Тэр бол үнэн Бурхан бөгөөд мөнх амь билээ. (1 Иохан 5:18-20)

18. [ ] Бурханы үг "энэ нь бичигдсэн" гэдэг нь Сатаныг ялж чадах цорын ганц хүч гэдгийг та мэдэх үү? Бурханы үг болох Есүс Христийг хэрэгтэй үе бүртээ урь.

19.[ ] Сатаны эсрэг ялах цорын ганц хүч бол Бурханы үг юм. Тиймээс ялахын тулд Сатаны мэдэлд байдаг дэлхийн хүч бус Бурханы үгтэй байх хэрэгтэй. Есүс Христийн нэр бол хүч юм. Хэрэв та итгэж, эргэлзэхгүй бол Бурханы үг нь таны тунхаглах үг юм. Муу ёрын сүнснүүдийг өөрийн төлөвлөгөө, ухаанаар бус Ариун Сүнсний хүчээр зайлуул. Өөрийгөө даатган Эзэнийг урьж, чөтгөрийг эсэргүүц. Түүний нигүүсэл таныг бүрхэх болно. Шуурган дунд зүрхийг тань Түүний амар тайван хучих болно. Тэд түүнийг Хурганы цус, өөрсдийн гэрчлэлийн үгээр ялжээ. Тэд үхэн үхтлээ амиа хайрлаагүй юм. (Илч 12:11)